

СҮХБААТАР АЙМГИЙН НАРАН СУМЫН 2022 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН ТАЙЛАН

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

2022 оны 09 сард албан хэрэг хөтлөлтийн явцад зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийг бүрдүүлж, зааврын дагуу хөтөлж, дээд газраас ирж буй албан бичиг эрхийн актыг хүлээн авч, бүртгэн удирдах албан тушаалтанд танилцуулж, холбогдох албан тушаалтанд шийдвэрлүүлэхээр шилжүүлж, шийдвэрлэлтийн хугацаа, биелэлтэнд хяналт тавьж ажиллалаа.

-07-р сарын 21-09-р сарын 21-ны байдлаар дээд газраас 58 нийт албан бичиг ирснээс, хариутай бичиг 23 ирж, 19 албан бичгийн хариуг хугацаанд нь барагдуулж, хугацаа болоогүй 4 албан бичиг байна.

-Мөн нийт 8 эрх зүйн баримт бичиг ирснээс Аймгийн Засаг даргын Захирамж 6, Аймгийн Засаг даргын албан даалгавар 2 ирж хэрэгжиж байна.

Дотоодын ажлын талаар:

2022 оны 09-р сарын байдлаар;

- 1.Сумын Засаг даргын А-Захирамж – 12
- 2.Сумын Засаг даргын Б-Захирамж - 9
- 3.Засаг даргын албан бичиг -15
- 4.ЗДТГ-ын даргын А-Тушаал - 4
- 5.ЗДТГ-ын даргын Б-Тушаал - 5
- 6.ЗДТГ-ын даргын албан бичиг – 12

Өргөдөл гомдлын талаар:

2022 оны 09-р сарын байдлаар иргэдээс Засаг дарга болон Тамгын газрын дарга, холбогдох албан тушаалтнуудад хандаж 1 өргөдөл гомдол ирснээс шийдвэрлэгдсэн 1, шийдвэрлэлтийн хувь 100%.

Архивын ажлын талаар:

□ Архивын данс бүртгэлийг шинэчлэн, Төрийн архивт 2011-2016 оны баримтыг цахим болон цаасан хэлбэрээр тушаахаар тоо бүртгэлийн ажил хийгдэж эхлээд байна.

□ 09 сарын байдлаар архиваас иргэн, албан тушаалтанд нийт 5 хадгаламжийн нэгжийг ашиглуулж, лавлагаа хуулбарыг олгосон байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР

Үндсэн ажилын хүрээнд
Нийт үзлэг-204
Урьдчилан сэргийлэх-113
Амбулаторт-75

Артерийн гипертензин эрт илрүүлэг-19

Чихрийн шижин эрт илрүүлэг-23

Жирэмсний хяналтанд байгаа-14

Шинээр хамрагдсан-7

Жинэлсэн хүүхдийн тоо-113

Эмнэлэгт хэвтсэн-34

Холын дуудлага-27

Төвийн дуудлага-77

Дусал тариа-257

Судас тариа-568

Булчин тариа-74

Арьсан доорх тариа-26

Уян зүү-5

Боолт-19

Сэргээн засах: Нил улаан туяа-13

Хэсэгчилсэн зөөлөн бариа-13

Утлага-6 хүнд үйлчилгээ үзүүлсэн байна

Лаборатори: Шээсний шинжилгээ-8

В,С вирусын шинжилгээ-6

ДОХ,Тэмбүү шинжилгээ-2

Сахар-3

Covid-58

Цагаан хорхой-98

Олон нийтийг хамарсан үйл ажиллагааны талаар:

1. Зам тээврийн осолд өртсөн хүнд үзүүлэх анхны тусламж, Хараа хяналтаа сайжруулъя, хурдаа хас, хамгаалалтын бүс зүүх зэрэг зөвлөмжүүдийн “НАРАН ЭМТ” пэйж хуудсаар иргэдэд хүргэсэн. Хандалт-200 гаруй



2. Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэх иргэдийн авто машин орж гарах замыг чөлөөлж, аюулгүй байдлыг хангах зорилгоор машины зогсоолын эвдэрч хэмхэрсэн хэсгүүдийг янзалж сайжруулсан.

3. Сумын цагдаагийн хэлтэстэй хамтран “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ” постер хийж иргэд болон хүүхдүүдийг аянд нэгдүүлж жолооч нарын аюулгүй байдлыг хангаж, суудлын бүсээ заавал зүүх шаардлагыг тавьж ажилласан.



“Зам хөндлөг гарах Алтан дүрэм” зөвлөмжийг бэлтгэж сургууль цэцэрлэгийн хүүхдүүд болон эцэг эхчүүдэд 56ш зөвлөмжийг тараан ажилласан.



Хэвтэн эмчлүүлсэн 6 иргэнд “Идэвхитэй дасгал хөдөлгөөн”-ний талаарх сургалтыг зохион байгуулсан.



Дэлхийн үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын өдрөөр “Эмийн аюулгүй байдал эмийг зөв хэрэглэе” сэдэвт построудыг цахимаар иргэдэд хүргэсэн.



Шинэ хичээлийн жил эхэлж буйтай холбогдуулан ажилчдын ЕБС, СӨБ-ийн 26 хүүхдэд хичээлийн хэрэгслийн багцийг 867.100 төгрөгөөр авч нийгмийн баталгааг ханган ажиллаж байна.



Ёс зүйн багаас “Хандлага дор Хүндлэл” уриатайгаар 14 хоногийн аян зохион байгуулж дараах үйл ажиллагааг зохион байгуулсан. 9 сарын 14нд нээлт хийж, ажилчидад төлөвлөгөөг танилцуулж ажилчдадаа сэтгэлийн үгэн мэндчилгээгээр угтан авсан.



ТӨСӨВ САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

8-р сарын санхүүгийн гүйлгээг хуваарийн дагуу үндсэн ба нэмэлт дансаар хийж ,төсвийн гүйцэтгэлийн мэдээг маягтын дагуу гаргаж СА-ы даргаар хянуулж ажиллалаа.Санхүүжилт хүрэлцээгүйн улмаас гэрэл цахилгаан дээр 73558.17 төгрөгний өртэй гарсан Энэ өрийг 9 сард барагдуулж ажиллана.

Нийгмийн даатгалын тайланг 9-р сарын 5-ы дотор гаргаж, НД-ын байцаагчаар хянуулж ажиллалаа. 8-р сарын шилэн дансны мэдээллийг шивж оруулсан. Мөн захирамж, тушаалуудыг скайнердаж, pdf файлаар оруулсан. 2022 оны хагас жилийн тайлан, 2023-2024 оны төсвийн төсөөллийг маягтын дагуу хийж, СА-ы даргаар хянуулж ажиллалаа. Мөн шилэн дансны мэдээллийг хугацаанд нь оруулж ажиллалаа.

Аймгийн Төрийн санд хүсэлт илгээж, 12490000 төгрөгний эрхийг тавиулж ажиллалаа.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:

2022 оны хавар тарьсан модонд хяналт, мониторинг хийх ажлын хэсгийн шинэчлэн байгуулах засаг даргын А\75 дугаар захирамжыг гаргаж багийн засаг дарга, байгаль хамгаалагч нарын хамтаар хяналт мониторингийн ажлыг хийж гүйцэтгэлээ. Сумын хэмжээнд тарьсан 4466 ширхэг модноос ургалт хэвийн 4052, хүний буруутай үйл ажиллагаа, усалгаа зэргээс шалтгаалан ургаагүй мод 414, ургалтын хувь 90.7 хувь байна.



Цэцэрлэгт хүрээлэнгүүдэд 7 хоног бүр усалгаа хийж байна.



ТАТВАРЫН ЧИГЛЭЛЭЭР:

Татварын ерөнхий газраас зохион байгуулсан цахим сургалтанд хамрагдсан. Мөн 09сарын 08нээс 09сарын11 ны өдрүүдэд Сүхбаатар аймгийн татварын хэлтэст сургалтанд хамрагдсан. Татвар төлөгчид татварын холбогдолтой цахим сургалт болон зөвөлгөөг сумын групп шэйр хийж 41 хүн мэдээлэл авсан. Мөн өөрийн хариуцсан ААН-ээр явж онцгой албан татварын лац болон төлбөрийн баримт олголтын талаар хяналт тавьсан.

Татварын орлогын холбоотойгоор 08сарын 20ноос 09сарын 20нд орсон орлого

1. Газрын төлбөрт-6000
2. Малын тоо толгойн албан татварт -1255400
3. Мөнгөн хадламжийн хүүгийн орлого-468264,83
4. Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар-75000
5. Улсын тэмдэгтийн хураамж-23100
6. Үл хөдлөх хөрөнгийн албан татварт-647464.93
7. Цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан албан татвар-5043292,29 зэрэг орлого төвлөрөөд байна.

2022оны 8сарын 31 байдлаар сумын нийт орлого-99031767,33 төгрөг буюу 88%-ийн орлогыг сумын холбогдох дансанд төвлөрүүлээд байна.

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР:


2022-2023 оны Шинэ хичээлийн жилийг зохион байгуулах ажлын хэсэг сургуулийн захирлын тушаалын дагуу хуралдаж хичээлийн шинэ жилийн нээлттэй уяалдуулан, чингис хааны эш хөргийг хэрхэн залах, БШУС-ын 2022 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн А\289 тоот удирдамжийн дагуу зохион байгуулсан.

МУ-ын Ерөнхийлөгчийн 2022 оны 07 дугаар сарын 11-ны өдрийн “Эзэн богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай” 159-дүгээр зарлигийг нийт даяар уншигчдад сонордуулах албыг сумын Засаг даргын орлогч Ч.Идэрчулуун, Чингис хааны намтар түүхийг иргэдэд түгээн дэлгэрүүлэх үйлийг хөтлөгч О.Ганболд, Хөгжмийн багш “Эртний сайхан монгол аялгуу” хөгжмийг эгшиглүүлж, багш нарын хурлын танхимд залсан.

Чингисийн суу алдар, түүхэн үйл хэргийг суралцагчдад таниулах, эрхэмлэн дээдлэхийг АУБ нар ангийн хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохируулан мэдээлэл өгч ажилласан. Мөн сургуулийн болон ангийн цахимд группэд цахим хичээлүүд байршуулах ажлыг зохион байгуулсан.



Олон улсын багш солилцооны хөтөлбөрийн хүрээнд БНСУ-ын Жусан бага сургуультай ээлжит хурлаа хийж цашид хэрхэн хамтарч ажиллах талаар санал бодлоо солилцож ажилласан.



БНСУ-ын Жусан бага сургуулийн хамтын ажиллагааны хүрээнд сургуулийнхаа танилцуулга болон 4-р ангийн суралцагчдын хичээл үйл ажиллагааг цахимаар танилцуулах ажлыг БДЗАН-ийн ахлагч нар болон сургалтын менежер хамтран зохион байгууллаа.



Малчдын нийгмийн хамгааллын төслөөс зохион байгуулж буй, Насан туршийн боловсролын багш нарыг чадавжуулах сургалтанд НТНБагш хамрагдаж мэдлэг арга зүйгээ дээшлүүллээ.

“Үндэсний бичиг соёлын өдөр – 2022” номын санчдын нэгдсэн чуулга уулзалт, сургалтад 2022-09.15-17 ны өдрүүдэд номын санч хамрагдаж мэдлэг аргай зүйгээ дээшлүүлсэн.

Аймгийн ГБХЗХГ-аас “Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний арга зүй өгөх” сургалт 2022.09.19-ны өдөр зохион байгуулагдаж мэргэжлийн арга зүйгээ дээшлүүллээ.



Зөвлөн туслах багийн үйл ажиллагаа:

БШУГ-ын зөвлөн туслах баг 8 хүний бүрэлдэхүүнтэй ирж ажиллах хугацаанд багш, удирдлагуудын бичиг баримт, үйлчилгээний ажилчдын эрүүл ахуй, хоол үйлдвэрлэлийн байдалтай танилцаж, заавар зөвлөгөө өгч ажиллалаа.



УБ хотын 84-р сургуулийн зөвлөх багш Б.Лхагвацэрэн багшийг урилгаар авчирч 2022.09.13-17-ныг хүртэл багш, удирдлагуудад 2 өдрийн сургалтыг зохион байгуулж, багшийн хөтөлбөр, төлөвлөлт, хичээл тус бүр дээр сууж анализ дүгнэлт хийж харилцан санал бодлоо солилцож ажилласан. Мөн сургуулийн удирдлагуудтай нэг бүрчлэн уулзаж, сургуулийн стратеги төлөвлөлт, хүүхэд хамгааллын бодлого, эрүүл мэндийн бодлого, багш хөгжлийн хөтөлбөр зэрэгт өөрийн санаагаа тусгаж, засан сайжруулж ажиллалаа.

Боловсролын чанарын шинэчлэлийн хүрээнд бага болосролын монгол хэлний арга зүйг сайжруулах, хичээл, сургалтын үр дүнг үнэлэх сургалтыг УБ хот БЕГ-ын мэрэгжилтэн П.Одсүрэн багшийг урж 2022.09.17-18-ны өдрүүдэд зохион байгууллаа.



Монголын багш нарын баярыг угтан “Залуу багшийг чадавхжуулах” хөтөлбөрийг сургууль дээрээ 3 баг болгон зохион байгуулж, тэргүүлэх зэрэгтэй багш нар залуу багш нартаа мэргэжил арга зүйн ур чадвар олгох сургалт, хөтөлбөр төлөвлөлт, нэг хичээлийн хөтөлбөр боловсруулах талаар заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.

Хүүхдийн хөгжил- хамгаалал- оролцоо:

Тухайн байгууллагад шинээр ажилд орсон багш, ажилчдад хүүхэд хамгааллын сургалт мэдээллийг зохион байгуулж, сургуульд мөрдөн ажиллах ХХ-ын бодлого, батламж, нууцын гэрээг танилцуулан гарын үсэг зуруулж, гарын авлагаар дамжуулан зөвлөгөө өгч хамтран ажиллалаа.



2022-2023 оны хичээлийн жилийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд:

ЭМСайдын 2017 оны А\145 тоот тушаалын 1-р хавсралтын 2.1 дэх заалтад тусгагдсан багш ажилтанг Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлэгтэй гэрээ байгуулж ажилласны үр дүнд нийт бага боловсролын 6 багш, Дотуур байрны-1 багш, Хоол үйлдвэрлэлтэй ажиллаж буй 5 ажилтан, нийт 12 багш ажилтанг хуваарийн дагуу 2022.08.26-ны өдөр үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж ажилласан.

Эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд 1-р багц буюу 18-30 насныхны багш, ажилчдын судалгааг гаргаж хамруулах ажлыг зохион байгуулж байна. Нийт 4 багш, ажилтан хамрагдана.

Байгууллагын хэмжээнд ковидын халдвар авсан багш, ажилтны судалгааг гаргаж, тандалт хийж ажилласны үр дүнд 8-р сард ковидын халдвар авсан 3 багш, гэрийн тусгаалалтанд эмчлэгдэж ажилдаа ороод ажиллаж байна. Мөн байгууллагын хэмжээнд ариутгал, халдваргүйжилтийг 2-3 удаа хийж ажилласан.

Сургуулийн болон дотуур байрны гадаад, дотоод орчинд эрсдлийн үнэлгээ хийж эрсдэлийг арилгах ажлын төлөвлөгөө гаргаж ажилласан. Үүнд:

1. Дотуур байрны их цэвэрлэгээг хуваарь гаргаж багш ажилчдын хүчээр хийж гүйцэтгэн цэвэрлэгээний байдалтай удирдлагууд танилцаж заавар зөвлөгөө өгч ажилласан.
2. Сургуулийн дотор талын асахгүй байгаа 10 ш гэрлийг шинээр солих ажлыг зохион байгуулсан.
3. Дотуур байрны болон сургуулийн гадна талд гэрэлтүүлэг хийх ажлыг зохион байгуулж шинээр 3 лед гэрэл суурьлууллаа.
4. Суралцагчдын гадна 00-д өдөр тутам ариутгал, халдваргүйжилтийг үйлчилгээний ажилчид хуваарийн дагуу хийж байна.

ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ:

2022-2023 оны хичээлийн жил эхлэхтэй холбогдуулан бүлэг бүр хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон агуулгаар үйл ажиллагааны төлөвлөлтийг боловсруулж, сургалтын 6 чиглэлээр хичээл үйл ажиллагаа зааж байна. Мөн дасан зохицох 14 хоногийн дадал хэвшлийн төлөвлөлт, аргачлалыг хийж батлуулан ажилласан.

БШУЯ-аас дэвшүүлсэн “2022-2023 оны хичээлийн жилийн зорилго, зорилт”- ын хүрээнд багш ажилчдаас санал авч, ажлын төлөвлөгөө боловсруулсан.

Хувилбарт сургалтын 35 хүүхдийн маршрутыг багийн дарга нартай хамтран гаргаж, багцаа шинэчилсэн. Мөн хувилбарт сургалтын хүүхдүүдэд өгөх сургалтын хөтөлбөрийг батлуулан жишиг даалгавраа нас насны ангиллаар бэлтгэж байна.

Аймгийн БШУГ-ын ажлын хэсэг ирж ажилласан бөгөөд мэргэжилтэн бүх багш нарын хичээл дээр сууж, бичиг баримттай нь танилцан зөвлөгөө заавар өгсөн.

Бүлгүүдийн өдрийн дэглэм, хүүхэд авах тарах үеийн цагийн зохицуулалтыг гаргаж, байгууллагын facebook хаяг болон бүлгүүдийн хаягт байршуулсан.



Хүүхдийг хөгжүүлэх чиглэлээр

Байгууллагаас хүүхдийн хөдөлгөөн эрүүл мэндийг дэмжих зорилготой явагдсан “Спорт өдөрлөг” бүлгийн 98 суралцагчийг хамруулж, нас насны онцлогоор буухиачлан өрсөлдсөн.

“Хүүхэд ба ном” үйл ажиллагааг сарын турш зохион байгуулж хүүхдүүд аав ээжээрээ уншуулсан үлгэрээ зургийг нь зураад ангийн хүүхдүүддээ ярьж өгч үгийн баялагаа нэмэгдүүлж мөн өөрийгөө илэрхийлэх чадвараа сайжруулан суралцаж байна.

“Бяцхан илтгэгч” үйл ажиллагааг сар бүр зохион явуулдаг. Энэ сарын үйл ажиллагаа “Миний гар бүл сэдвийн хүрээнд явагдаж нийт 52 хүүхэд оролцлоо.



Эрүүл ахуй, хоол хүнс, халдварүйжүүлэлт

ХАБЭА ажлын хүрээнд гал тогооны тогооч, туслах ажилтанд заавар зөвөлгөө өгч аюулгүй ажиллагааны зааварчилгаанд гарын үсэг зуруулсан.

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээндээ 08,26-ны өдөр бүрэн хамрагдаад ирсэн. Багш ажилчдын 16 ширхэг дэвтэрийг хүлээн авч бүртгэлжүүлэн ажилласан. 2 багш цээж зураг наагаагүй зөрчилтэй байсаныг холбогдох багш нарт хэлж зөрчлийг арилгах арга хэмжээг авсан.

Мэргэжлийн байгууллагаар хортон шавьж устгалыг хийлгэсэн байсаныг баримтыг үндэслэн бүртгэн авч бүртгэлжүүлсэн.

Ундны усыг шинжилгээнд явуулж шинжилгээний хариугаа хүлээн авч бүртгэлжүүлсэн.



СОЁЛЫН ТАЛААР:

Соёл урлагийн ажилтаны 29 дэх өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх “Соёлын орон зай” арга хэмжээний хөтөлбөр гарган 9-р сарын 9-ний өдөр зохион байгууллаа. Энэхүү ажлын хүрээнд Нээлтийн арга хэмжээ, Монгол Улсын Соёлын тухай, Соёлын өвийн тухай хууль, Угийн бичиг хөтлөх арга зүйн мэдээлэл, бүжгийн болон хөгжмийн дугуйлангийн бүртгэл, волейболын бооцоот тэмцээн, баярын цэнгүүн зэрэг арга хэмжээг амжилттай зохион байгуулсан.

9-р сарын 5-аас даргын үүрэг гүйцэтгэгч Б.Оюунзул жирэмсэний амралт авсан тул хөгжмийн багш Л.Чинбат үүрэг гүйцэтгэгчээр томилогдсон. Хөгжмийн багшаар Д.Эрдэнэцэцэгийг томилон ажилуулж байна.

7 дугаар сарын 18-аас эхлэн хөгжмийн дугуйлан, бүжгийн дугуйланг үргэлжлүүлэн хичээллүүлж, хөгжмийн дугуйланд 5 иргэн, бүжгийн дугуйланд 10 хүүхэд суралцсан. 9-р сарын 12-с шинээр 13 хүүхэд цахилгаан хөгжим, үндэсний хөгжим, үкүлэлэ, гитар хөгжмийн дугуйланд суралцаж байна.

НИЙГМИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:

2022 оны 09 дүгээр сарын 21- ний өдөр “ӨӨРЧЛӨЛТИЙГ ӨӨРӨӨСӨӨ” залуучуудын чуулга уулзалтыг зохион байгуулж Тэргүүн, тэргүүлэгчдийг сонгож залуучуудын оролцоог идэвхижүүлж ажиллалаа.



ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

**ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН**

М.БЯМБАСҮРЭН